



“ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ” ХК-Д

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,  
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байр,  
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41

2019.8.15 № 2/1284  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тендерийн баримт бичгийг  
хянасан тухай**

*Д. Дармаа-г  
Улаанбаатар  
2019.08.15*

Танай компаниас зарласан “ERP программ хангамж нийлүүлэх” ЭТТ/201901144 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичигт холбогдох гомдлыг “Стар систем” ХХК-аас ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд хянан үзлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Захиалагч тендерийн баримт бичгийг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан тендерийн жишиг баримт бичиг, гэрээний маягт болон тендер шалгаруулалтад холбогдох бусад журам, аргачлалын дагуу бэлтгэнэ” гэж заасан байх тул захиалагч “Мэдээллийн систем нийлүүлж, суурилуулах тендерийн жишиг баримт бичиг”-т үндэслэн тендерийн баримт бичгийг бэлтгэсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчсөн гэж үзэхгүй.

Тус тендер шалгаруулалтын баримт бичгийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт (ii) Тендерт оролцогчдод тавигдах шаардлагын хангаж буй байдал 30% “Хэрэгжүүлэх багийн гишүүдийн глобал стандартын ERP систем (SAP, Oracle EBS)-ийн зөвлөхийн сертификат авсан байдал” гэж заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Тендерт оролцогчийн техникийн чадавхи, туршлагыг ажил, бараа, үйлчилгээний агуулга, онцлог, тоо хэмжээг харгалзан дараахь үзүүлэлтийн аль нэгийг үндэслэн тогтооно” гэж, 16.1.1-д “тендерт оролцогчийн удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар” гэж заасан байх тул захиалагчийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт өрсөлдөөнийг хязгаарласан гэж үзэхгүй.

Иймд тус тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулахыг үүгээр мэдэгдэж байна.

ОРОН ТООНЫ ГИШҮҮН

С.ЦОГТГЭРЭЛ

*[Handwritten signature]*

*[Handwritten signature]*

*М. Ганзориг  
Хэрэгжүүлэх багийн гишүүн  
2019.08.15*

000364/11/19

"ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ" ХК

ТТС № 3895

Бүртгэсэн № 1179 карт № 1179

Огноо 2019.08.16

... цаг ... минутанд

.....-д

шилжүүлэв.

Хуудасны тоо: 1x